



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/59/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: <a href="mailto:enkhdalai.d@audit.mn">enkhdalai.d@audit.mn</a> Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 51-261628 Цахим хаяг: <a href="mailto:dabaadorja@audit.gov.mn">dabaadorja@audit.gov.mn</a> Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК Захирал О.Бурмаа Утас: 99168735 Цахим хаяг: <a href="mailto:aetb@audit.mn">aetb@audit.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/848

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН  
БЭЛТГЭЛ СУРГАЛТЫН ТӨВ  
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Б. НАРАН-ИДЭР  
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу алдаа, зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан, өр төлбөрийг үлдэгдэлтэй, барагдуулаагүй зэрэг 400.9 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн, залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2 заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Төрийн өмчит зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 243 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа “Буянт Ухаа спортын ордон”-ын засвар үйлчилгээний ажлыг дуусгаж, улсын комисс хүлээн авснаар “Буянт ухаа спортын ордон” ТӨААТҮГ-ыг “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” ТӨААТҮГ-т нэгтгэн зохион байгуулсан.

Z:\Yawsan\_Bichig\2024\0325 SNAG-59.Docx

0001051100

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 528 дугаар тогтоолоор тус байгууллагын бүтэц орон тоог 5 албатай, нийт 72 хүртэл орон тоотой байхаар баталсан байна.

### **Аудитын гол асуудал**

ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 806 дугаар тогтоолоор Буянт Ухаа спортын ордон ТӨААТҮГ-аас 249 нэрийн 51,888.7 сая төгрөгийн анхны өртөгтэй, 4,292.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгө, 55.1 сая төгрөгийн авлага, 44.7 сая төгрөгийн бараа материал, 154.4 сая төгрөгийн өр төлбөрийг балансгаас балансад шилжүүлэн бүртгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

ТӨБЗГ-ын 2022 оны “Үндэсний Шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлах тухай” 569 дүгээр тогтоолоор нийт орлогыг 839.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 839.5 сая төгрөгөөр баталсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 243 дугаар тогтоолоор “Буянт Ухаа спортын ордон” ТӨААТҮГ-тай нэгтгэн, өөрчлөн зохион байгуулагдсан боловч эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг шинэчлэн батлаагүй байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	394,523.48	2,132,261.37
1.1.2	Дансны авлага	24,649,298.99	227,741,299.41
1.1.6	Бараа материал	110,285,272.63	155,010,966.39
1.1.7	Урьдчилж төлсөн зардал		14,950,000.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>135,329,095.10</b>	<b>399,834,527.17</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,564,653,506.72	48,671,293,670.38
1.2.2	Биет бус хөрөнгө	1,460,833.38	4,015,833.38
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,566,114,340.10</b>	<b>48,675,309,503.76</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,701,443,435.20</b>	<b>49,075,144,030.93</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
2.1.1.1	Дансны өглөг	525,000.00	29,748,725.27
2.1.1.2	Цалингийн өглөг	178,143,054.52	213,239,320.94
2.1.1.4	НДШ - ийн өглөг	159,852,475.17	213,239,320.94
2.1.1.5	Богино хугацаат зээл	99,386,608.00	322,349,247.18
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	138,389,187.20	121,620,629.29
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>733,783,336.04</b>	<b>961,687,896.55</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>733,783,336.04</b>	<b>961,687,896.55</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	2,020,478,530.99	31,372,723,217.16
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	817,900,316.08	26,756,359,080.05
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		985,082,626.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,870,718,747.91)	-11,000,708,788.83
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>967,660,099.16</b>	<b>48,113,456,134.38</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>1,701,443,435.20</b>	<b>49,075,144,030.93</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>48,045,600.00</b>	771,704,000.00
2	<b>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</b>		
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>48,045,600.00</b>	<u>771,704,000.00</u>
8	Хүүгийн орлого		23,045.14
8	Бусад орлого	172,858,830.57	182,709,264.58
9	Борлуулалт, маркетингийн зардал	78,405,450.31	746,180,631.71
10	Ерөнхий ба удирдлагын зардал	334,629,681.51	312,774,878.41
11	Бусад зардал	31,125,141.23	107,894,318.42
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	17,546.85	20,158.11
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(22,500.00)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(223,238,295.63)</b>	<b>(212,415,660.71)</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(223,238,295.63)</b>	<b>(212,415,660.71)</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>(223,238,295.63)</b>	<b>(212,415,660.71)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
26	Бусад олз (гарз)		
27	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(223,238,295.63)</b>	<b>(212,415,660.71)</b>
28	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг(алдагдал)</b>		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,020,478,530.99	817,900,316.08		-1,679,945,112.34	1,158,433,734.73
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлангийн үеийн цэвэр ашиг				-190,773,635.57	-190,773,635.57
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,020,478,530.99	817,900,316.08	0.00	-1,870,718,747.91	967,660,099.16
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
12	Тайлангийн үеийн цэвэр ашиг				-212,415,660.71	-212,415,660.71
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт	29,352,244,686.17	25,938,458,763.97	985,082,626.00	-8,917,574,380.21	47,358,211,695.93
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	31,372,723,217.16	26,756,359,080.05	985,082,626.00	-11,000,708,788.83	48,113,456,134.38

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/ төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>172,171,977.46</b>	<b>659,499,582.55</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	39,345,600.00	472,939,000.00
	Бусад мөнгөн орлого	132,826,377.46	186,560,582.55
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага (-)</b>	<b>215,130,523.07</b>	<b>674,339,529.94</b>
	Ажиллагчдад төлсөн	39,918,295.00	196,487,664.58
	НДШ-д төлсөн		35,000,000.00
	Ашиглалтын зардалд төлсөн	25,464,742.24	166,496,587.24
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,618,603.80	11,592,124.00
	Хүүний төлбөрт төлсөн		13,535,800.00
	Татварын байгууллагад төлсөн	774,618.00	7,702,580.93
	Даатгалын төлбөрт төлсөн	6,983,806.50	216,030.00
	Бусад мөнгөн зарлага	138,370,457.53	243,308,743.19
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(42,958,545.61)</b>	<b>-14,839,947.39</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		21,727.17
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		21,727.17
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>		21,727.17
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>95,464,200.00</b>	<b>58,000,000.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	95,464,200.00	58,000,000.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>54,000,000.00</b>	<b>41,464,200.00</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	54,000,000.00	41,464,200.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>41,464,200.00</b>	<b>16,535,800.00</b>
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)		20,158.11
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,494,345.61)</b>	1,737,737.89
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,888,869.09</b>	<b>394,523.48</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>394,523.48</b>	<b>2,132,261.37</b>

## 2.5 Зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Үзүүлэлтүүд	2022 оны гүйцэтгэл	2023 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Нийт орлого, Үүнээс:</b>	<b>220,904.4</b>	<b>839,670.0</b>	<b>954,465.5</b>	<b>114,795.5</b>	<b>113.7</b>
2	<b>Нийт зардал, Үүнээс:</b>	<b>444,542.7</b>	<b>839,476.2</b>	<b>1,166,872.2</b>	<b>327,396.0</b>	<b>139.0</b>
2.1	Үйл ажиллагааны зардал	109,913.0	629,607.2	854,097.5	<b>224,490.3</b>	<b>135.7</b>
2.2	Удирдлагын зардал	334,629.7	209,869.0	312,774.7	<b>102,905.7</b>	<b>149.0</b>
3	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал</b>	<b>(223,638.3)</b>	<b>193.8</b>	<b>(212,406.7)</b>	<b>(212,600.5)</b>	<b>(109,601.0)</b>
4	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>(223,638.3)</b>	<b>174.4</b>	<b>(212,415.6)</b>	<b>(212,590.0)</b>	<b>(121,797.9)</b>
5	Төсвийн нийт төлбөр, Үүнээс:	774.6	72,000.0	32,702.5	<b>(39,297.5)</b>	<b>45.4</b>
6	Төрийн өмчийн ногдол ашиг		20,854.8	-		
7	Нийт ажиллагсдын тоо	11.0	27.0	17.3	<b>(9.7)</b>	<b>64.1</b>
8	Нийт цалингийн сан	39,318.3	300,000.0	196,487.6	<b>(103,512.4)</b>	<b>65.5</b>
9	Нэг ажилтны дундаж цалин	297.9	925.9	944.4	<b>18.5</b>	<b>102.0</b>
10	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	2.0	1.0	1.3	<b>0.3</b>	<b>130.0</b>
11	Хөрөнгө оруулалт		-	-		
12	Нийт авлага	24,649.3	24,649.3	227,741.3	<b>203,092.0</b>	<b>923.9</b>
	Үүнээс: Найдваргүй		-	-		
13	Нийт өглөг	733,783.3	785,990.4	961,687.9	<b>175,697.5</b>	<b>122.4</b>
	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	733,783.3	785,990.4	961,687.9	<b>175,697.5</b>	<b>122.4</b>

### 3 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 313.6 сая төгрөгийн 8 алдаа илэрснийг аудитын явцад залруулж баталгаажуулав.

/мянган төгрөгөөр/													
	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг 262,530.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	262,530.0			1	262,530.0	1	262,530.0	-	-		
2	ТӨБЗГ-ын 77 тогтоолоор 40 ш үнэ төлбөргүй ирсэн сандал ширээ 5,121.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс буруу бүртгэж өмчийн дүн нэмэгдүүлэх гүйлгээг авлага бууруулах бичилт хийж тайлагнасан	1	5,121.0			1	5,121.0	1	5,121.0				
3	6,415.5 мянган төгрөгөөр зардалд бүртгэх гүйлгээг өглөгийн дансыг бууруулж дутуу тайлагнасан.	1	6,415.5			1	6,415.5	1	6,415.5				
4	Бараа материалыг 42.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	42.7			1	42.7	1	42.7				
5	5,121.0 мянган төгрөгөөр өмчийн дансыг дутуу тайлагнасан.	1	5,121.0			1	5,121.0	1	5,121.0				
6	Борлуулалтын орлогыг 14,000.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	14,000.0			1	14,000.0	1	14,000.0				
7	Зардлыг 6,372.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	6,372.8			1	6,372.8	1	6,372.8				
8	Барьцаа дансны 14,000.0 мянган төгрөгийг зардлаар тайлагнасан.	1	14,000.0			1	14,000.0	1	14,000.0				
		8	313,603.0	-	-	8	313,603.0	8	313,603.0		-	0	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 400.9 сая төгрөгийн зөрчил 3 илэрснээс, 27.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх 373.6 сая төгрөгийн алдааг засах 2 зөвлөмж өгсөн.

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	тоо	Тоо	Дүн
1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу 27.3 сая төгрөгийн гүйлгээг санхүүгийн тайланд бүртгэсэн. Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй	1	27,322.4			1	27,322.4						
2	Тайланд ХХОАТ 63.сая төгрөг, газрын төлбөр 122.4 сая төгрөг, бусад татварт 0.2 сая төгрөг нийт 186.5 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй, барагдуулаагүй.	1	186,524.8					1	186,524.8				
3	Санхүүгийн тайланд төлөгдөөгүй НДШ-ийн өр төлбөр 187.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, барагдуулаагүй байна.	1	187,097.8					1	187,097.8				
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>400,945.0</b>			<b>1</b>	<b>27,322.4</b>	<b>2</b>	<b>373,622.6</b>				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 839.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 839.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													

1	Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих 122 мэдээллээс 839.6 сая төгрөгийн 120 мэдээллийг бодитой, иж бүрэн мэдээлээгүй байна.	1	839,670.0			1	839,670.0		
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>839,670.0</b>			<b>1</b>	<b>839,670.0</b>		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
2	Өмнөх оны аудитаас өгсөн 2 зөвлөмж хэрэгжүүлээгүй. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/937 дугаар захирамжаар 23787 кв газрыг 7 жилийн хугацаатай олгосон гэрчилгээний хугацаа 2022 онд дууссан, газрын гэрчилгээг шинэчлэн гаргуулах 2. Үндсэн хөрөнгөөс 24,035.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй хөрөнгийг бараа материалын дансруу шилжүүлэн бүртгэх.	1				1			
	<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>			
	<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>839,670.0</b>			<b>2</b>	<b>839,670.0</b>		